

# АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ (2013 ОНЫ ЭХНИЙ 09 САРЫН БАЙДЛААР)

## I. ТӨСӨВ:

### Төсвийн орлого

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор эхний 09 сард аймгийн төсөвт 56812.8 сая төгрөгийн орлого орохоос 56820.9 сая төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 100.0 хувьтай байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 4621.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 5152.9 сая төгрөгийн орлогыг оруулжээ.


Аймгийн төсвийн орлогын 90.9 хувийг тусламжийн орлогоор, 6.3 хувийг орлогын албан татвараар, 0.2 хувийг өмчийн татвараар, 1.1 хувийг бусад албан татвараар, 0.6 хувийг татварын бус орлогоор, 0.9 хувийг тусгай зориулалтын орлогоор бүрдүүлж байна.



### Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр 43140.5 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Нийт зарлагын 46.3 хувийг цалин хөлс, 4.2 хувийг НДШ, 0.8 хувийг ЭМД, 28.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 19.7 хувийг татаас ба шилжүүлэг, 0.9 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.



### Өглөг, авлага

Эхний 09 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагууд 327.0 сая төгрөгийн өртэй байна.

Өглөгийн 8.7 хувийг түлш халаалтын зардал, 15.5 хувийг тээврийн зардал, 12.5 хувийг цалин, 7.8 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 5.8 хувийг хоолны зардал, 6.4 хувийг эмийн зардал, 41.0 хувийг бусад зардал тус тус эзэлж байна. Тухайн сард шинээр үүссэн өглөг 182.9 сая төгрөг буюу нийт өглөгийн 55.9 хувийг эзэлж байна.

## II. АРИЛЖААНЫ БАНК.

Манай аймагт 2013 онд арилжааны 5 банкны салбар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна. Арилжааны банкны салбаруудаас аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл эхний 09 сард 112935.4 сая төгрөг болж, 58.8 хувь нь ХААН банк, 24.0 хувь нь Төрийн банк, 0.6 хувь нь Капитал банк, 16.6 хувь нь Хас банк-д ногдож


байна. Зээлийн өрийн үлдэгдлийн 65.9 хувийг 2013 оны эхний 09 сард олгосон зээл эзэлж байна. Нийт зээлийн 0.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл байна. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс 47297.5 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна.

Байгууллага, иргэдийн хугацаатай ба хугацаагүй хадгаламж 47487.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 10739.5 сая төгрөг буюу 29.2 хувиар өссөн байна.

### III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ:

#### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 29335.4 сая төгрөг, зарлага 24098.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 6357.0 сая төгрөг буюу 27.7 хувиар, зарлага 2291.7 сая төгрөг буюу 10.5 хувиар тус тус өссөн байна. Нийгмийн даатгалын сайн дурын орлого 783.4 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 170.7 сая төгрөг буюу 27.8 хувиар, эрүүл мэндийн сангийн орлого 596.8 сая төгрөг буюу 35.8 хувиар өсчээ. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 21454.1 сая төгрөг болсны 80.4 хувийг өндөр настны, 12.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 6.7 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.1 пунктээр, өндөр настны тэтгэвэр 0.1 пунктээр буурч, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр 0.2 пунктээр өссөн байна.



Аймгийн хэмжээнд 12323 хүнд тэтгэвэр олгосны дотор өндөр насны тэтгэврийг 9232 хүнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 1898 хүнд, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 934 хүнд тус тус олгожээ.

Эхний 09 сард 1844 хүнд 789.8 сая. төгрөгийн тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс тэтгэмж авагчдын тоо 247 хүнээр буюу 15.5 хувиар өсч, олгосон тэтгэмжийн хэмжээ 225.7 сая төгрөгөөр буюу 40.0 хувиар өссөн байна.

Эмнэлэгийн санхүүжилтэд 1682.3 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 284.0 сая төгрөг буюу 14.9 хувиар буурч, ажилгүйдлийн тэтгэмж 120.1 сая төгрөг буюу 3.3 дахин өсчээ.

#### Нийгмийн халамж:


Эхний 09 сард нийгмийн халамжийн сангаас /давхардсан тоогоор/ 30840 хүнд 7172.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 4411 хүнээр буюу 16.7 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 2480.3 сая.төгрөг буюу 52.8 хувиар өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж авагчдын 9.2 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 3.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 4.4 хувь нь ахмад настанг асарч буй иргэд, 0.2 хувь нь алдар цолтой ахмадууд, 31.4 хувь нь алдарт эхийн одонтой эхчүүд, 14.9 хувь нь жирэмсэн болон нярай хөхүүл хүүхэдтэй эхчүүд байна. Нийгмийн халамжийн сангаас 7172.0 сая.төгрөгийн тэтгэвэр тэтгэмж олгосны 2255.4 сая.төгрөг буюу 31.4 хувийг халамжийн тэтгэвэрт, 1026.4 сая төгрөг буюу 14.3 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 57.1 сая төгрөг буюу 0.8 хувийг алдар цолтой ахмадуудад, 458.6 сая төгрөг буюу 6.4 хувийг ахмад настанг асарч буй иргэдэд, 342.0 сая төгрөг буюу 4.8 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд тус тус олгожээ.

### IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ:

Аймгийн хэмжээгээр 2012 оны эцэст төллөх насны нийт 1190.5 мянган эх мал тоологдсон. 2013 оны эхний 9 сарын байдлаар 1113.0 мянган мал буюу оны эхэнд тоологдсон нийт эх


малын 93.5 хувь нь төллөсөн байна. Урд оны мөн үед 901.5 мянган мал буюу оны эхний нийт эх малын мөн 93.0 хувь нь төллөөд байсан байна. Ингэний 43.9 хувь, гүүний 80.2 хувь, үнээний 85.4 хувь, эм хонины 94.4 хувь, эм ямааны 95.0 хувь нь төллөжээ.

### Мал төллөлтийн хувь, 2013 оны эхний 9 сарын байдлаар




Гарсан төлийн 99.1 хувь буюу 1111.4 мянган төл бойжиж байна. Өмнөх оны мөн үед гарсан төлийн 99.3 хувь буюу 900.4 мянган төл бойжиж байсан байна.

### Төл бойжилтын хувь, 2013 оны эхний 9 сарын байдлаар




Аймгийн хэмжээгээр 2013 оны эхний 9 сарын байдлаар 19 тэмээ, 748 адуу, 772 үхэр, 7740 хонь, 9196 ямаа буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.62 хувьтай тэнцэх 18475 том мал зүй бусаар хорогдоод байна.

### Зүй бусаар хорогдсон том мал, 2012 оны эхний 9 сарын байдлаар




Нийт хорогдсон малын 0.1 хувийг тэмээ, 4.0 хувийг адуу, 4.2 хувийг үхэр, 41.9 хувийг хонь, 49.8 хувийг ямаа эзэлж байна.

### Зүй бусаар хорогдсон том малын бүтэц, төрлөөр



2013 оны эхний 9 сарын байдлаар Баян-Өндөр суманд 276 толгой мал буюу оны эхний нийт малын 0.1 хувь, Бүрд суманд 731 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.3 хувь, Бат-Өлзий суманд 1390 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 1.0 хувь, Баруунбаян-улаан суманд 1054 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.7 хувь, Баянгол суманд 226 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.13 хувь, Гучин-Ус суманд 319 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Есөнзүйл суманд 388 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.3 хувь, Өлзийт суманд 183 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.14 хувь, Зүүнбаян-Улаан суманд 2481 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 2.5 хувь, Богд суманд 141 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 0.06 хувь, Нарийн тээл суманд 266 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.2 хувь, Сант суманд 144 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.12 хувь, Тарагт суманд 580 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.53 хувь, Төгрөг суманд 12 толгой мал, Уянга суманд 1648 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хайрхандулаан суманд 401 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.22 хувь, Хужирт суманд 1288 толгой мал буюу оны эхэнд тоологдсон малын 0.9 хувь, Хархорин суманд 6916 толгой мал буюу оны эхэнд тоологдсон нийт малын 3.6 хувь, Арвайхээр суманд 31 толгой мал тус тус зүй бусаар хорогдсон байна.

### Зүй бусаар хорогдсон малын тоо, сумаар




Аймгийн хэмжээнд 2013 оны эхний 9 сард өвчнөөр 978 толгой мал хорогдсон ба энэ нь Бат-Өлзий суманд 321 толгой мал, Баруунбаян-Улаан суманд 9 толгой мал, Гучин-ус суманд 37 толгой мал, Есөнзүйл суманд 65 толгой мал, Төгрөг суманд 2 толгой мал, Уянга суманд 281 толгой мал, Хайрхандулаан суманд 19 толгой мал, Хужирт суманд 225 толгой мал, Хархорин

суманд 17 толгой мал, Арвайхээр суманд 2 толгой мал тус тус хорогдоод байна. Урд оны мөн үед өвчнөөр 167 толгой мал хорогдсон байжээ.

Зүй бусаар хорогдсон том мал дотор хээлтэгчийн хорогдол эхний 9 сарын байдлаар 3120 толгой байгаа ба оны эхний нийт хээлтэгчийн 0.2 хувь нь хорогдоод байна. Нийт хорогдсон том малын 16.9 хувь нь хээлтэгч мал байна.


Аймгийн түүхий эдийн захад ямааны ноолуур 65000 төгрөг, тэмээний шир 15000 төгрөг, адууны шир 30000 төгрөг, үхрийн шир 1.8-2.3 метр урттай нь 30000 төгрөг, 2.3 метрээс дээш урттай нь 35000 төгрөг, хонины нэхий 12000 төгрөг /өлөн гэдэс ороогүй үнэ/, ямааны ноолууртай арьс 6000 төгрөгийн үнэ ханштай байна. Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд хонины арьсны үнэ 84.6 хувиар, ямааны ноолуурын үнэ 44.4 хувиар, үхрийн ширний үнэ урд оноос том нь 40.0 хувь, жижиг нь 50.0 хувиар тус тус өссөн, ямааны арьсны үнэ өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 20.0 хувиар өссөн байна.

### Ямааны ноолуурын дундаж үнэ, төгрөг




Аймгийн хэмжээнд 1631.2 га-д үр тариа, 330.3 га-д төмс, 163.6 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх онтой харьцуулахад үр тариа 1134.8 га-гаар бага, төмс 3.0 га-гаар илүү, хүнсний ногоо 4.1 га-гаар мөн илүү тариалсан. Ургац хураалтын хувьд үр тариа хураалт 221.2 га-с 216.3 тн, төмс 299.2 га-с 3552.8 тн, хүнсний ногоо 153.2 га-с 2010.7 тн ургац хураагаад байна. Малын тэжээл 774.3 га-д тариалсан ба хураалт 2579.3 тн байна. 9 сарын 30-ны байдлаар 27938.1 тн хадлан, 3706.5 тн гар тэжээл бэлтгээд байна.

### Төмс, хүнсний ногоо хураан авалт



### Малын тэжээл

#### бэлтгэлт




### V. АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 9 сард 11015.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 10329.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 67.8 хувиар, борлуулалтын орлого 75.9 хувиар өссөн байна.

Энэхүү өсөлтөд нүүрс олборлолт, цэвэр ус, талх, нарийн боов, гурил, хэрчсэн гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, гутал, оёдол, модон эдлэл, барилгын материал зэрэг үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8,9 хувиас 2,2 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Харин архи, зайрмаг үйлдвэрлэл 20,0-35.8 хувиар буурсан байна.


Үйлдвэрлэл явуулсан цэг салбарыг мэдээнд нэмж хамруулсан нь аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлтөд зохих хэмжээгээр нөлөөллөө.

### Үйлдвэрлэлт, борлуулалт, тэрбум төгрөг 2012-2013 он



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүнээс нүүрсний борлуулалт 807,9 сая төгрөг, хүнсний бүтээгдэхүүн борлуулалт 5113,2 сая төгрөг, оёдолынх 237,5 сая. төгрөг, гутлынх 195,6 сая.төгрөг, мод, модон эдлэл, тавилгын борлуулалт 843,9 сая.төгрөг, бусад бүтээгдэхүүний борлуулалт 1748,3 сая төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийнх 1383,4 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс нийт борлуулалтад нүүрс олборлолт 2,8 пунктээр, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн борлуулалт 7,6 пунктээр, модон эдлэл, тавилгынх 6,2 пунктээр буурч, хүнсний бүтээгдэхүүн борлуулалт 6,9 пунктээр, оёдолынх 0,4 пунктээр, гутлынх 0,8 пунктээр, бусад бүтээгдэхүүн борлуулалтынх 8,5 пунктээр өсчээ.

### Борлуулсан бүтээгдэхүүн салбарын бүтцээр




## VI. ХОЛБОО, ТЭЭВЭР, ХУДАЛДАА:

### Тээвэр

Авто замын тээврээр 2013 оны эхний 9 сард давхардсан тоогоор 152,6 мянган зорчигч зорчиж, 19,2 мян. тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 20,3 мян. хүн буюу 15,3 хувь, тээсэн ачаа 2.8 мян.тн буюу 17,1 хувиар өсчээ.

### Зорчигч эргэлт, тээсэн ачаа





Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр авто замын тээврийн салбарын орлого 2013 оны эхний 9 сард 1253.4 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 209.5 сая төгрөг буюу 20.1 хувиар өсчээ.

### Холбоо

Холбооны тарифын орлого өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 19.2 хувиар өсч 377.5 сая төгрөг болсоны дотор хүн амаас орсон орлого 18.9 хувиар өсч 125.2 сая төгрөгт хүрсэн байна. Телефон цэгийн тоо 1012 байгаа нь урьд оны мөн үеийнхээс 43-аар буурсан байна

## VII. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ:


Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлгийн 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж түүний үндсэн дээр инфляцыг тооцдог.

2013 оны 09 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарыхаас 5.2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеийхээс 13.4 хувиар, 2010 оны 12-р сарынхаас 31.8 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 08 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 213 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 26.8 хувийх нь үнэ өсч, 3.3 хувийх нь буурч, 69.9 хувийх нь үнэ тогтвортой байлаа.

Энэ сард өмнөх сарынхаас хонины ястай махны үнэ 3.3 хувиар, үхрийн цул махны үнэ 8.2 хувиар, ямааны ястай махны үнэ 5.2 хувиар, үхрийн ястай махны үнэ 12.5 хувиар, манжин 23.1 хувиар, байцаа 16.7 хувиар, сонгино 13.3 хувиар буурч, адууны ястай махны үнэ 6.0 хувиар, цувдайны үнэ 33.3 хувиар, цагаан будааны үнэ 22.2 хувиар, шар будааны үнэ 5.6 хувиар, шар тосны үнэ 6.3 хувиар, маслоны үнэ 11.1 хувиар, алим мандарин 7.1 хувиар, улаанлоольны үнэ 11.1 хувиар, зөөлөн чихэрний үнэ 6.3 хувиар, шоколадны үнэ 6.7 хувиар, компотны үнэ 6.0 хувиар, бохьны үнэ 11.1 хувиар, архины үнэ 7.7 хувиар, аймгийн үйлдвэрийн архины үнэ 4.0 хувиар, тамхины үнэ 11.1 хувиар, биеийн тамирын хувцасны үнэ 12.5 хувиар, модон авдарны үнэ 11.1 хувиар, модон ор 10.0 хувиар, бэлэн хувцасны үнэ 3.6-25.0 хувиар тус тус өссөн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 53.0 хувийх нь буюу 113 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 2.8 хувийх нь үнэ буурч, 44.1 хувийх нь үнэ тогтвортой байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс сүү, аарц, гурил, будаа, хүнсний ногоо, ааруул, тамхи, архи, дотуур, гадуур хувцас, гутал, гэр ахуйн хэрэгсэл, жимс, жимсгэнэ, бүх төрлийн мах, бензин, цэвэр усны үнэ, зэргийн үнэ 3.1 хувиас-81.1 хувиар нэмэгдсэн байна.



## VIII. НИЙТ БАРАА ГҮЙЛГЭЭ:

Аймгийн хэмжээнд 2013 оны эхний 9 сард 34567.7 сая төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 6332.7 сая төгрөг буюу 22.4 хувиар өссөн байна.

Бараа гүйлгээний орлого өмнөх оны мөн үеийнхээс 22.4 хувиар өсөхөд барааны дэлгүүрийнх 40.1 хувиар, хүнсний дэлгүүрийнх 12.3 хувиар, авто сэлбэгийнх 13.6 хувиар, барилгын материалынх 35.3 хувиар, авто засварын газрынх 11.4 хувиар, шатахуун борлуулалтынх 26.5 эм борлуулалтынх 5.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Бараа гүйлгээний орлогын 5.2 хувийг барааны дэлгүүр 24.9 хувийг хүнсний дэлгүүр, 2.9 хувийг авто сэлбэгийн дэлгүүр, 1.5 хувийг барилгын материалын дэлгүүр, 2.0 хувийг ресторан


бар, 2.0 хувийг цайны газар, 0.2 хувийг түүц 4.4 хувийг контейнер, 2.1 хувийг авто засварын газар, 52.0 хувийг шатахуун борлуулалт, 2.8 хувийг эм борлуулалтын орлого эзэлж байна.

### IX.АЖИЛГҮЙЧҮҮД:

Аймгийн ХХҮХ-т бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 1048 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1298 хүнээр буюу 2.2 дахин буурчээ. 09 сард ажилгүй 186 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй ажилгүй байсан 341 иргэн ажилд зуучлагдан орж, 820 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 635 буюу 60.6 хувь нь 15-34 насны залуучууд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 19.6 хувь нь дээд, 5.0 хувь нь тусгай дунд, 5.2 хувь нь мэргэжлийн анхан шатны, 37.4 хувь нь бүрэн дунд, 21.3 хувь нь бүрэн бус дунд, 10.3 хувь нь бага, 1.2 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дээд боловсролтой иргэдийн тоо 2.8 пунктээр, боловсролгүй иргэдийн тоо 0.6 пунктээр, мэргэжлийн анхан шатны боловсролтой иргэдийн тоо 1.5 пунктээр, тусгай дунд боловсролтой иргэдийн тоо 2.2 пунктээр буурч, бүрэн бус дунд боловсролтой иргэдийн тоо 0.2 пунктээр, бүрэн дунд 6.0 пунктээр, бага боловсролтой иргэдийн тоо 0.9 пунктээр тус тус өссөн байна.Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо 9 сард 341 болжээ.Ажилд зуучлагдан орсон нийт иргэдийн 28.1 хувь нь төрийн төсөвт байгууллагад, 57.5 хувь нь нөхөрлөл компанид, 14.4 хувь нь хоршоонд оржээ.

#### Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо



### X.АЖЛЫН ШИНЭ БАЙР:

Аймгийн хэмжээнд 09 сарын байдлаар 1575 ажлын байр шинээр бий болжээ.


Ажлын байрны 23.1 хувь нь ХАА-н салбарт, 24.2 хувь нь боловсруулах үйлдвэрт, 21.5 хувь нь барилгын салбарт, 8.3 хувь нь худалдааны салбарт, 22.9 хувь нь бусад салбарт бий болжээ.Ажлын байрны 32.7 хувь нь аймгийн төвд 67.3 хувь нь сумдад бий болжээ. Шинээр бий болсон ажлын байрны 32.7 хувь нь Арвайхээр суманд, 11.4 хувь нь Уянга суманд, 4.6 хувь нь Сант суманд, 3.3 хувь нь Баянгол суманд, 9.8 хувь нь Батөлзий суманд, 2.9 хувь нь Нарийнтээл суманд, 7.4 хувь нь Хархорин суманд, 27.9 хувь нь бусад сумдад бий болжээ.Ажилд орсон нийт хүмүүсийн 44.8 хувь буюу 705 нь эмэгтэйчүүд байна.

### XI.ЭРҮҮЛ МЭНД:

Аймгийн хэмжээнд эхний 09 сард 2115 эх амаржиж, өмнөх оны мөн үеийнхээс 171 эхээр буюу 8.8 хувь, төрсөн хүүхдийн тоо(амьд төрөлтөөр) 2115 болж, 166 хүүхэд буюу 8.5 хувиар өссөн байна.

Нэг хүртэлх насандаа 29 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 12 хүүхдээр буюу 29.3 хувиар буурсан байна.





Халдварт өвчнөөр эхний 09 сард 1075 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 377 хүнээр буюу 54.0 хувиар өссөний дотор гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 496 хүнээр буюу 3.5 дахин, салхин цэцгээр өвчлөгчдийн тоо 59 хүнээр буюу 2.9 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 33 хүнээр буюу 60.0 хувиар, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 7 хүнээр буюу 12.9 хувиар, заг хүйтнээр өвчлөгчдийн тоо 2 хүнээр буюу 16.7 хувиар өсчээ.

Вируст гепатитаар өвчлөгчдийн тоо 134 хүнээр буюу 2.3 дахин, трихоминазаар өвчлөгчдийн тоо 39 хүнээр буурчээ.

Халдварт өвчин өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өндөр суманд 12 хүнээр, Хархорин суманд 34 хүн буюу 2.2 дахин, Арвайхээр суманд 406 хүн буюу 2.1 дахин, Хужирт суманд 26 хүн буюу 2.3 дахин, Гучинус суманд 13 хүнээр буюу 2.8 дахин, Хайрхандулаан суманд 20 хүнээр буюу 2.0 дахин, Төгрөг суманд 5 хүнээр буюу 2.0 дахин, Сант суманд 4 хүнээр буюу 26.7 хувиар, Бүрд суманд 7 хүнээр буюу 3.2 дахин өсч, Бат-Өлзий суманд 13 хүнээр буюу 3.6 дахин, Богд суманд 35 хүнээр буюу 3.6 дахин, Тарагт суманд 17 хүнээр буюу 2.4 дахин буурчээ.

Арвайхээр суманд гахайн хавдраар 563 хүн, Хархорин суманд 26 хүн, Тарагт суманд 3 хүн, Төгрөг суманд 2 хүн, Баянгол суманд 12 хүн, Гучин ус суманд 15 хүн, ЗБУлаан суманд 8 хүн, Хайрхандулаан суманд 16 хүн, Хужирт суманд 14 хүн, Нарийнтээл суманд 25 хүн, Сант суманд 1 хүн, Бүрд суманд 8 хүн, Есөнзүйл суманд 3 хүн, Баянгол суманд 12 хүн, Богд суманд 2 хүн, Өлзийт суманд 1 хүн, Уянга суманд 1 хүн, тус тус өвчилжээ.



## ХИЙГЭМТ ХЭРЭГ:

Аймгийн хэмжээнд 09 сард 392 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 20 гэмт хэргээр буюу 4.9 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 63.5 хувь нь сумдад, 36.5 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 8 хүүхдээр буюу 33.4 хувиар буурсан байна. Хулгайлах гэмт хэргийн 51.4 хувийг хувийн өмчийн хулгай, 38.5 хувийг малын хулгай, 10.1 хувийг мототцикийн хулгай тус тус эзэлж байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс Хужирт суманд 20.0 хувиар, Богд суманд 2.5 дахин, Гучин ус суманд 66.7 хувиар, Есөнзүйл суманд 80.0 хувиар, Өлзийт суманд 3.5 дахин, Уянга суманд 33.3 хувиар, Арвайхээр суманд 3.6 хувиар, Хайрхандулаан суманд 55.5 хувиар өсч, Баян-Өндөр суманд 22.2 хувиар, Сант суманд 2.4 дахин, Тарагт суманд 2.5 дахин, Хархорин суманд 36.6 хувиар, Нарийнтээл суманд 40.0 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэрэгт холбогдсон 418 сэжигтэн, яллагдагчийн 225 хүн буюу 53.8 хувь нь 18-35 хүртэл насных, 173 хүн буюу 41.1 хувь нь 35-аас дээш насных, 20 хүн буюу 4.8 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 1.9 хувь нь оюутан, 13.1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 25.6 хувь нь малчин, 41.6 хувь нь ажилгүй иргэд байна.

Түр саатуулсан тээврийн хэрэгсэл 3218 болж өмнөх оны мөн үеийнхээс 270 тээврийн хэрэгслээр буюу 7.8 хувиар, авто машин жолоодох эрхээ хасуулсан жолооч 74 хүнээр буюу 22.0 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 17.6 хувь нь гудамж талбайд үйлдэгдсэн байна. Нийт хэргийн 33.4 хувь нь согтуугаар, 25.7 хувь нь бүлэглэн үйлдсэн хэргүүд эзэлж байна.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 2.1 дахин өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 6.4 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 12.2 хувиар буурчээ.

Гэмт хэргийн улмаас 486.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеийнхээс 13.2 сая төгрөг буюу 2.8 хувиар өсчээ. Нийт хохирлын 64.7 хувь буюу 314.9 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэргийн улмаас 72 хүн нас баржээ. Үүний 26.4 хувь нь хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас, 62.5 хувь нь золгүй учирлаар, 11.1 хувь нь бусдын гарт амь үрэгдсэн байна. Эмэгтэйчүүд оролцсон гэмт хэрэг өмнөх оны мөн үеийнхээс 18.5 хувиар өсчээ.

Аймгийн хэмжээнд 09 сард 1154 хүн эрүүлжүүлэгдэж, 378 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 91 буюу 8.6 хувиар, баривчлагдсан хүний тоо 58 буюу 18.1 хувиар өссөн байна.



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

MAIN INDICATORS

6/10/2013

Үзүүлэлтүүд	/Indicators/	Хэмжих нэгж /Unit/	2011	2012	2013	2013/ 2012%
Төсвийн орлого revenue/	/budget	сая.төг mln.tog	3643.4	3489.8	5152.9	147.7
Төсвийн зарлага expenditure/	/Budget	сая.төг mln.tog	27790.1	40139.8	43140.6	107.5
Зээлийн өрийн үлдэгдэл debts/	/Remainder of loan	сая.төг mln.tog	58343.3	78795.7	112935	143.3
Үүнээс: хугацаа хэтэрсэн outstanding debts/	/whom:	сая.төг mln.tog	178.5	231.8	337.1	145.4
Хадгаламж	/Deposits/	сая.төг mln.tog	30948.7	36747.6	47487.1	129.2
Төллөсөн хээлтэгч	/Breeding stock/	мян.тол /thous.heads/	811.7	901.5	1113	123.5
Бойжсон төл young animals/	/rearing of	мян.тол /thous.heads/	794.2	900.4	1111.4	123.4
Том малын зүй бус хорогдол animals/	/Losses of adult	мян.тол /thous.heads/	20.7	6.9	18.4	266.7
Ургац хураалт /total crops / :						
Үр тариа /Cereals/		га/ hectare	1144.0	127.6	216.3	169.5
Төмс/Potatoes/		га/ hectare	2683.8	3341.8	3552.8	106.3
Хүнсний ногоо/Vegetable/		га/ hectare	1557.0	1960.2	2010.7	102.6
Байгалийн хадлан /gross hay harvest/		тн /tn/	21630.2	24641.4	27938.1	113.4
Гар тэжээл / hand made fodder/		тн /tn/	3360.8	3617.4	3706.5	102.5
Аж үйлдвэрийн НБ industrial outрут/	/Gross	сая.төг mln.mog	4501.5	6563.6	11015.1	167.8
Борлуулсан бүтээгдэхүүн production/	/Sold	сая.төг mln.tog	3850.1	5869.3	10329.8	176.0
Тээсэн ачаа	/Carried freight/	мян.тн /thous.tn	15.2	16.4	19.2	117.1
Зорчигч эргэлт turnover/	/Passenger	мян.хүн.км /thouspass.km/	35278	37176.3	43236.4	116.3
Холбооны орлого communication/	/Revenue of	сая.төг mln.tog	193.7	228.4	377.5	165.3
Телефон цэг telephones/	/Number of	тоо/number/	1074	1055	1012	95.9
Ажилгүйчүүд /Unemployment/		хүн/people/	3843	2346	1048	44.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид infectious disease cases/	/number of	хүн/people/	1001	698	1075	154.0
1 хүртэл насандаа эндсэн хүүхэд at age of 1 years/	/infant deaths	хүн/people/	51	41	29	70.7
Бүртгэгдсэн хэрэг/Offences/		тоо/number/	348	412	392	95.1
Хэрэгт холбогдогсад /Offenders/		хүн/people/	314	399	418	104.8

**1.ТӨСӨВ**

**BUDJET**

**I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО,оны үнээр,мян.төг**

*STATE BUDGET REVENUE OF AIMAG, at current prices, thous.tog*

Төсвийн орлого	2012		2013		Budget revenue
	гүйц	төл	гүйц	төл	
Татварын орлого	3293541.6	4493936.6	4812643.4		Tax revenue
Орлогын албан татвар	1944925.0	3829616.9	3604765.9		-Individuals
- Өмчийн татвар	90331.8	90617.3	146081.6		-Property tax
- Бусад татвар	896985.5	207742.4	619675.7		-Other tax
Татварын бус орлого	166546.4	127889	340215.8		Non-tax revenue
Хөрөнгийн орлого	29689.4	0	67		Capital revenue
<b>Дүн</b>	<b>3489777</b>	<b>4621825.6</b>	<b>5152926.2</b>		<b>Total</b>
Орлогын эх үүсвэр					
Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг		9787300.0	9787300.0		-Corporate tax
Тусгай зориулалтын шилжүүлгээс		26636224.6	26636224.6		
Аймаг нийслэлээс авсан санхүүгийн дэмжлэг		11412216.3	11243289.3		-Value added tax
Сум дүүргээс авсан тэгшитгэл		4355301.1	4001224.5		- Excise tax
<b>Дүн</b>	<b>0.0</b>	<b>52191042</b>	<b>51668038</b>		<b>Total</b>

**I.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,оны үнээр,мян.төг**

*STATE BUDGET EXPENDITURE OF AIMAG, at current prices, thous.tog*

Төсвийн зарлага	2012		2013		Budget expenditure
	гүйц	төл	гүйц	төл	
-Цалин хөлс	24106513	20897642	19961873		-Wages&salaries
-Нийгмийн даатгалын шимтгэл	1928375	1929651.2	1814206.3		-Social security contribution
-Эрүүл мэндийн даатгал	503341.5	368698.8	358802.8		-Health insurance
-Бараа үйлчилгээний бусад зардал	8764047	15600503	12119101.8		-Goods and services expenses
Татаас ба шилжүүлэг	3314505	8952791.9	8485834.3		-Subsidie & transfers
-Хөрөнгө оруулалт	1523076	386993.4	400769.4		-Investment
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>40139857</b>	<b>48136280.1</b>	<b>43140587.6</b>		<b>TOTAL EXPENDITURE</b>

06-Oct-13

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.

1.2 ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА сумаар, оны үнээр, мян.төг  
 BUDGET REVENUE, EXPENDITURE ,by soum , at current prices , thous.tog

Сум	Орлого Revenue			Зарлага Expenditure		
	2013			2013		
	төл	гүйц	%	төл	гүйц	%
Баян-Өндөр	65243.0	68027.3	104.3	1357060.1	1316238.6	97.0
Бүрд	66228.1	63511.8	95.9	1099266.3	1085764.2	98.8
Бат-Өлзий	179196	207236.9	115.6	2272755.2	2165641.3	95.3
ББ-Улаан	59070.6	71495.3	121.0	1369273.1	1047984.1	76.5
Баянгол	79692.2	68464.6	85.9	1253959.5	1248484.8	99.6
Гучин-Ус	61759.1	58270	94.4	1210745.0	1011703.5	83.6
Есөнзүйл	59655.2	62689.6	105.1	1241924.8	1146125.6	92.3
Өлзийт	47145.8	53495	113.5	1078382.0	922081.9	85.5
ЗБ-Улаан	62569.4	81142.3	129.7	1062581.6	1098229.0	103.4
Богд	102995.1	99730.4	96.8	1579120.2	1649551.0	104.5
Нарийнтээл	100069.9	99724.9	99.7	1616727.7	1395674.8	86.3
Сант	72124.2	71020.5	98.5	1276912.8	1189040.1	93.1
Тарагт	65628.7	62999.6	96.0	1173047.0	1098400.8	93.6
Төгрөг	57937	63144.9	109.0	1238965.5	1186262.5	95.7
Уянга	245352.6	435550.3	177.5	2895778.4	2656432.7	91.7
Хайрхандулаан	60022.4	56066.7	93.4	1208386.9	1135228.5	93.9
Хужирт	224117.8	280131.8	125.0	2356090.7	2166227.0	91.9
Хархорин	593790.5	663924.4	111.8	3740227.2	3601263.4	96.3
Арвайхээр	2305228	2291300	99.4	8110620.1	7649638.5	94.3
Сум дүн Soum total	4507825.6	4857926.2	107.8	37141824.1	34769972	93.6
Аймгийн шууд	114000.0	295000	258.8	10994456.0	8370615.3	76.1
Аймаг дүн Aimag total	4621825.6	5152926.2	111.5	48136280.1	43140587.6	89.6

07-Oct-13

СЭЗТСХ-ийн мэдээг үндэслэв.





	Нийт өглөг	Үүнээс:							
		ажиллагсдад олгох цалин	Нийгмийн даатгалын шимтгэл	хураамж/Эрүүл мэндийн даатгалын	Гэрэл цахилгаан	Тулш халаалт	Тээвэр	Шуудан холбоо	
Эхний үлдэгдэл	<b>218548.8</b>	5504.1	31589	0	717.8	5743.1	35209.5	98.2	
Тухайн сард төлөгдсөн өглөг	<b>74439.3</b>	33520.2	7248.9	0	225	2000	9623.9	89.7	
Тухайн сард шинээр үүсэн өглөг	<b>182909.8</b>	19485.9	1262.4	0	6426	24656.5	25212.4	0	
Эцсийн үлдэгдэл	<b>327019.3</b>	41049.8	25572.5	0	6918.8	28399.6	50798	8.5	
өглөг Үүсэн хугацаа	31-60 өдөр	<b>269721.8</b>	37489.7	23046	0	6918.8	28399.6	25601.7	8.5
	61-120 өдөр	<b>52026.8</b>	3560.1	1286.4	0		0	23810.3	0
	121 өдрөөс дээш	<b>5270.7</b>	0	1240.1	0	0	0	1386	0

**БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА /мян.төг/**

д/д	Үзүүлэлтүүд	Indicators	ХААН банк	Төрийн банк	ХАС банк	К
1	Монгол банкнаас арилжааны банкуудад хийсэн зузаатгал		10966036.0	2529836.0	1540186.0	19
2	Банкны кассын орлого		50884750.0	28172002.4	37102206.4	37
3	Монгол банкинд гүйлгээнээс орсон татаас		24752030.0	312650.0	2886200.0	99
4	Банкны кассын зарлага		38181096.0	27541244.3	37092308	37
5	Зээлийн өрийн бүх үлдэгдэл		66470133.0	27082129.5	18687728.4	69
6	Үүнээс: Хугацаа хэтэрсэн зээл		231639.0	28145.2	77345.6	
7	Байгууллага, иргэдийн хувийн хадгаламж		26622367.0	11179081.1	7468214.5	53
8	Дүн		218108051.0	96845088.5	104854188.9	9

**Нийгмийн даатгалын сангуудын зарцуулалтын мэдээ**

Үзүүлэлтүүд	Өссөн дүнгээр
	мян.төг

1	Нийгмийн даатгалын сангуудын нийт орлого				Төлөвлөгөө	27104207.4		
					Гүйцэтгэл	29335405.7		
					Хувь	108.2		
	Орлого	Үүнээс	Төсвийн дотац			Төлөвлөгөө	17961813.3	
						Гүйцэтгэл	17961813.3	
						Хувь	100.0	
			НДШ-ийн орлого			Төлөвлөгөө	9142394.1	
						Гүйцэтгэл	11373592.5	
						Хувь	124.4	
		Үүнээс	Нийгмийн даатгалын сайн дурын орлого			Төлөвлөгөө	412332.5	
						Гүйцэтгэл	783426.2	
						Хувь	190.0	
			Үүнээс	ЭМД-ын сангийн орлого			Төлөвлөгөө	2016230.0
							Гүйцэтгэл	2260255.8
							Хувь	112.1
Үүнээс	ЭМД-ын хураамж			Төлөвлөгөө	101270.0			
				Гүйцэтгэл	195127.6			
				Хувь	192.7			
2	Зарлага	Тэтгэвэр			Хүний тоо	12323		
					Олгосон нь	21454116.9		
		Үүнээс	Өндөр настны			Хүний тоо	9232	
						Олгосон нь	17254216.6	
			ХБИргэдийн			Хүний тоо	1898	
						Олгосон нь	2756490.9	
		Тэжээгчээ алдсаны			Хүний тоо	934		
					Олгосон нь	1443409.4		
		Тэтгэмж			Хүний тоо	1844		
					Олгосон нь	789852.3		
		Эмнэлгийн санхүүжилт			Олговол зохих нь	1682312.1		
					Олгосон нь	1682312.1		
		Ажилгүйдлийн тэтгэмжид олгосон			Хүний тоо	191		
					Олгосон нь	172668.2		
		3	НДШ-ийн авлага				Бүгд	61553.3
						үүнээс	аж ахуйн нэгж	39899.7
							төсвийн	21653.6

НДХ-ийн мэдээг үндэслэв.

### НДС-уудын зарцуулалтын мэдээ /сумдаар/

Сум	НДШимтгэлийн орлого	Зарлага			
		Тэтгэвэр	Тэтгэмж	Эмнэлгийн санхүүжилт	Ажилгүйдлийн тэтгэмж

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Хүний тоо	Олгосон	Хүний тоо	Олгосон	Олговол зохио	Олгосон	Хүний тоо	Олгосон
БаянӨндөр	175910.9	241848.6	137.5	524	879828.7	34	15164.2			6	70
Бүрд	153157.3	204706.6	133.7	369	610501.8	25	12494.7			4	33
БатӨлзий	276079.8	395754.1	143.3	536	891457	57	30317.6			2	10
ББ-Улаан	150540.7	185084.8	122.9	243	398453.2	18	11558.4			4	46
